

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.09.02

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Nvidia компанийн тайлан хүлээлтээс дээгүүр гарсан боловч 10 хувиар уналаа
- АНУ-ын 7-р сарын Core PCE индекс 2.6% болж тогтворжлоо
- БНХАУ-ын 8-р сарын PMI индекс 49.1 болж буурлаа
- БНХАУ-ын урт хугацаат зээлийн хүү 2.3%-д хэвээр хадгалагдлаа
- Хятадын шинжээчид 2024 онд 5%-д хүрнэ гэсэн таамаглалаа бууруулаад байна

2024 он 9-р сарын 2

Dow Jones	41,563.08
S&P 500	5,648.40
Nasdaq	17,713.62
DAX	18,906.92
FTSE 100	8,376.63
S&P/ASX 200	8,076.70
HANG SENG	17,685.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.55%	0.78%	4.59%	10.28%	19.30%	17.51%
S&P 500	1.01%	0.56%	5.65%	18.42%	25.08%	24.54%
Nasdaq	1.13%	-0.07%	5.59%	18.00%	26.24%	15.30%


2024 оны 9 сарын 2-ны 11:00



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-0.03%	1.56%	7.05%	12.87%	19.36%	19.81%
FTSE 100	-0.04%	0.59%	2.47%	8.32%	12.22%	17.35%

2024 оны 9 сарын 2-ны 11:00



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-0.18%	-0.10%	1.68%	6.40%	10.97%	7.36%
Hang Seng	-1.70%	-0.69%	4.31%	3.69%	-3.84%	-31.76%

2024 оны 9 сарын 2-ны 11:00





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

АНУ-ын индексүүд sideway хөдөлгөөнийг үзүүллээ

Өнгөрсөн долоо хоногт Nasdaq Индекс 0.92%-ийн уналтыг үзүүлэн даваа гарагийн хувьцааны арилжаа энэ жилийн хамгийн бага арилжааны идэвхтэй өдөр болж өнгөрлөө. Санхүү болон жижиглэн худалдааны салбарын компаниуд өсөлттэй байсан ч технологийн салбарын хувьцаанууд долоо хоногийн гүйцэтгэлээр хүчтэй хөдөлгөөнийг үзүүлээгүй байна.

Nvidia компанийн санхүүгийн тайлан танилцуулагдав

Зах зээлийн анхаарлын төвд байсан томоохон үйл явдлуудын нэг нь Nvidia компанийн тайлан байсан юм. Хэдийгээр борлуулалтын орлого 30 тэрбум ам.долларыг даван хүлээлтээс дээгүүр байсан ч зах зээл үүнийг хангалттай гэж үзээгүй тул хувьцааных нь ханш 10 хувиар унаад байна. Мөн тус компани 50 тэрбум ам.долларын хувьцаагаа эргүүлэн худалдаж авахаа мэдэгдээд байгаа нь анхаарал татахуйц үйл явдал боллоо.

Нэгж хувьцааны ашиг: 0.68 ам.доллар (хүлээлт 0.64 ам.доллар)

Орлого: 30.04 тэрбум ам.доллар (хүлээлт: 28.7 тэрбум ам.доллар)

АНУ-д инфляц тогтворжиж байна.

Баасан гарагт АНУ-ын худалдааны яамнаас ХНС-ийн инфляцын гол үзүүлэлт болох хувийн хэрэглээний зардлын үнийн индексийн (PCE) 7 сарын өсөлт 2.5 хувьтай гараад байна. ХНС-ийн зорилтот инфляцын түвшин жилийн 2 хувь байдаг ба уг түвшинд бага багаар ойртсоор байгаа юм.

Тус мэдээллийн дараа АНУ-ын засгийн газрын бондын үнэ бага зэрэг буурсан бөгөөд 2 жилийн хугацаатай сангийн өрийн бичгийн өгөөж 0.02 хувиар нэмэгдэж, 3.92 хувьд хүрчээ.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлд тулгарч буй бэрхшээл

Үл хөдлөх хөрөнгийн зах зээл сул хэвээр байж, гэрээ хийгдээгүй борлуулалт 7-р сард 5.5%-иар буурч, 2001 оноос хойших хамгийн доод түвшинд хүрэв. Үүний шалтгаан нь орон сууцны үнэтэй холбоотой асуудлууд болон хүүгийн хүлээлттэй холбоотой.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал





Эх газрын Хятадын хувьцаанууд уналттай байна

Хятадын хувьцаанууд буурчээ. Учир нь хэд хэдэн компанийн ашиг орлогын тайлангууд хүлээлтэд хүрээгүй нь зах зээлд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Шанхайн хөрөнгийн биржийн гол индекс болох Shanghai Composite 0.43%-аар буурсан бол томоохон компанийн хувьцааг багтаасан CSI 300 индекс 0.17%-аар унажээ. Харин Хонгконгийн Hang Seng индекс 2.14%-аар өссөн байна.

2024 онд эдийн засгийн өсөлт таамаглалд хүрэх нь эргэлзээтэй болов

Хятадын эдийн засагчид 2024 оны өсөлтийн таамаглалаа бууруулсан байна. Үүнд гол шалтгаан нь орон сууцны салбарын удаашрал болон дотоодын эрэлт сул байгаа явдал юм. Жишээлбэл, жижиглэн худалдааны борлуулалт энэ жил 4%-иар өсөх төлөвтэй байгаа нь өмнөх 4.5%-ийн таамаглалтай харьцуулахад буурсан үзүүлэлт юм.

Мөн хөрөнгө оруулалт 4.2%-иар өснө гэж үзэж байгаа нь өмнөх сарын 4.4%-ийн таамаглалаас доогуур байна. Эдийн засагчид хэрэглээний үнийн индексийн өсөлтийн таамаглалаа 0.6%-аас 0.5%-д хүргэн бууруулжээ. Хятадын эдийн засгийн төлөв буурсан нь тус улсын 2024 онд 5%-ийн өсөлтийн зорилтод хүрч чадахгүй байж магадгүй гэсэн таамаглалыг нэмэгдүүлж байна. Мөн Хятадын Төв банкнаас бодлогын хүүг дахин бууруулах болон арилжааны банкуудад тавигдах нөөцийн шаардлагыг багасгах зэрэг нэмэлт арга хэмжээ авч магадгүй гэж үзэж байна.

Мөнгөний бодлогод томоохон өөрчлөлтүүд ороогүй байна


























































Мөнгөний бодлогын хүрээнд Хятадын Төв банк банкны системд 300 тэрбум юань оруулсан ба зээл олгох хүүг 2.3%-д хэвээр хадгалсан байна. Мөн богино хугацааны, 7 хоногийн хугацаатай 471 тэрбум юань бүхий санхүүжилтийг банкны системд нийлүүлж, зээл олгох хүүг 1.7%-д хэвээр үлдээжээ.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
September 02, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
		 MICRO	 ZS	 DICK'S SPORTING GOODS	 C3.ai	 NIO	 AVGO	 BIG.LOTS	
		 華文集團 HELLGARD	 Zscaler	 DLTR	 HPE	 ICEL	 PATH	 ABM	
		 GitLab	 ASAN	 DOLLAR TREE	 CHPT	 fuelcellenergy	 UiPath	 GENESCO	
		 asana	 HealthEquity	 CIENA	 Casey's	 TORO	 samsara	 DOCSIS	
		 ascendis pharma	 ASND	 Hormel Foods	 CRDO	 LANDS' END	 DocuSign	 DOOO	
		 SPWR	 SPORTSMAN'S MANSION	 CORR	 CREDO	 SAIC	 planet.	 BRDY	
		 onstream	 OSI	 J.Jill	 AVAV	 AFFM	 smartstreet	 RENT	
		 PagerDuty	 CURV	 AMERICA'S CAR-MART	 Gopart	 KORN FERRY	 RENT THE RUNKY	 BRZE	
			 TORRID	 SIZES 10 TO 30	 sprinklr	 GIII	 brazz	 NKX	
			 DAK	 CONCRETE	 CONCRETE	 SHOE	 Quanex	 ZUMZ	
			 KNOT	 VERINT	 VERINT	 DZS	 zumiez		